

ХҮРД ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэнд талархаж, хурлын ажиллагаанд идэвхтэй, ажил хэрэгч оролцохыг хүсч байна.

Монгол улсын Гавьяат барилгачин, Зөвлөх инженер, “Хүрд” компанийн ерөнхий захирал, томоохон хувьцаа эзэмшигч Бүлтэнхүүгийн Энхжаргал 2023 оны 02-р сарын 03-ны өдөр хүнд өвчний улмаас таалал төгсөж, бидэнд нөхөж баршгүй хүнд гарз тохиолдсон харамсалтай мэдээг Хувьцаа эзэмшигч та бүхэнд дуулгая.

Б.Энхжаргал захирал маань Монгол улс зах зээлийн тогтолцоонд шилжсэн шилжилтийн үеэс эхлэн Хүрд /ХК/ компанийг үүсгэн байгуулж, тус компанийг бэхжүүлэх, ажилчдыг ажлын байраар хангах, үйлдвэрлэлийн баазыг шинээр барьж байгуулах, улсын болон гадаадын зээл, тусламжаар санхүүжиж буй барилга байгууламж, томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд компанийн хамт олныг дайчин шуурхай удирдан зохион байгуулж ирсэн чадварлаг удирдагч байлаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг өдөр тутмын 2 тогтмол хэвлэл /Өдрийн сонин, Зууны мэдээ/, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг Улаанбаатар телевиз, Монголын үндэсний олон нийтийн радиогоор 2 удаа зарлаж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллээ.

Компанийн 2022 оны санхүүгийн тайланг мөн өдөр тутмын хэвлэлд нийтэлж, Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүллээ.

Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдийн тоо болон хувь хэмжээнд өөрчлөлт гараагүй, 2023 оны 03-р сарын 23-ны байдлаар компанийн 135266 ширхэг хувьцааг 2021 онд 96 хүн эзэмшдэг байсан, одоо 99 хүн эзэмшиж байна.

Тайлант хугацаанд компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан бизнес төлөвлөгөө, удирдлагын зардал, компанийн үйл ажиллагаа, ажиллагсдын цалин хөлс урамшуулал, хөрөнгийн өсөлт бууралт, ногдол ашиг, удирдлагын урамшуулал олгох асуудалд анхаарал хандуулан ажиллаж ирлээ.

Компанийн ТУЗ 3 удаа хуралдаж, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах, ногдол ашиг болон удирдлагын урамшуулал олгох, компанийн хэтийн хөгжил, засаглалыг сайжруулахад зориулж шинэ залуу боловсон хүчин бэлтгэх, инженерүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж зэрэг эзэмшүүлэх, бизнес төлөвлөгөөний биелэлт, компанийн үйл ажиллагааг өргөтгөх, барилга угсралтын ажлын явцтай танилцах шинэчлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэлээ.

2021 онд компанийн нэгж хувьцаанд **1677** төгрөг, нийт **226,845.0** мянган төгрөгийн ногдол ашиг олгосон бол 2022 онд компанийн нэгж хувьцаанд **953.5** төгрөг, нийт **128,983.32** мянган төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2022 оны ажлын үр дүнд "хангалттай" гэсэн дүгнэлт өгснийг үндэслэн удирдлагын урамшуулал олгох журмын дагуу удирдлагын урамшилд **39.9 сая** төгрөг олгожээ.

2022 оны компанийн удирдлагын зардлыг **470,0** сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэл нь **396,8** сая төгрөг болж, **73,2 сая** төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ.

2022 онд компанийн чухал хэрэгцээт мэргэжлээр 6 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 12 хүн хамрагдаж, шинээр буюу мэргэжлийн зэргээ ахиулсан байна. Үүнд: Зөвлөх инженер, мэргэшсэн инженер, , Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан бэлтгэх, цахилгааны групп зэрэг, цахилгаан гагнуурчдын категорийн сургалт, аттестатчлал, кранчин, дохиочин бэлтгэх, хугацаа сунгуулах зэрэг болно. Эдгээр сургалтанд **42.0** сая төгрөг зарцуулжээ.

Компани санхүүгийн хувьд мөнгөн хөрөнгө, материалын зохих нөөцийг бүрдүүлж, эдийн засгийн хүчин чадал өсөн нэмэгдэж байна.

Компанийн үл хөдлөх хөрөнгө өөрчлөлттэй, **9** барилга байгууламж-**588.0** сая төгрөг болжээ. Сүхбаатар дүүргийн 7-р хороонд байрлах 26-р байрны зоорийн давхрыг бүртгүүлжснээр **112 сая** төгрөгөөр нэмэгдлээ.

Үндсэн хөрөнгө оны эхэнд **1,285.0** сая төгрөг байснаа оны эцэст **1,537.5** сая төгрөг болж өөрчлөгджээ.

Байгууллага хүмүүсээс авах БУА-ын санхүүжилт болон авлага оны эхэнд **6,7** тэрбум төгрөг байсан бол тайлант хугацаанд **6,3** тэрбум төгрөгөөр нэмэгдэж, **11,4** төгрөгөөр буурч, оны эцэст авлага **1,6** тэрбум төгрөг болж, авлага **5,1 тэрбум** төгрөгөөр буурсан байна.

Мөн байгууллага хүмүүст өгөх өглөг оны эхэнд **4,6 тэрбум** төгрөг байсан бол тайлант хугацаанд **3,2 тэрбум** төгрөгөөр нэмэгдэж , **4,6 тэрбум** төгрөгөөр буурч, оны эцэст **3,2 тэрбум** төгрөг болж өглөг **1,4** сая төгрөгөөр буурсан байна.

БУА-ын урьдчилгаа буюу захиалагчийн хөрөнгө оны эхэнд **3,04 тэрбум** төгрөг байсан бол оны эцэст **3,7 тэрбум** төгрөг болж, **0,66 тэрбум** төгрөгөөр өссөн байна.

Бид өнгөрсөн онд **6 тэрбум 975 сая** төгрөгийн БУА гүйцэтгэж, **1 тэрбум 766 сая** төгрөгийн орон сууцны үйлчилгээний ажил, нийт **8 тэрбум 777 сая** төгрөгийн барилга угсралт, ажил үйлчилгээ эрхэлж **7 тэрбум 276 сая** төгрөгийн зардал гаргаж, барилга угсралтын хувьд **4 тэрбум 792 сая** төгрөгийн ашигтай, **1** төгрөгийн БУА-ыг **83** мөнгөөр гүйцэтгэж, барилга угсралтын хувьд **17 %**-ийн ашигтай ажиллажээ. Дотоод аж ахуйн нэгжүүд: төмөр хийц **111 сая** төгрөг, бетон эдлэлийн үйлдвэр **22,1 сая** төгрөгний ажил үйлчилгээ, үйлдвэрлэл явуулж, материал хангамж **36,8 сая** төгрөгний борлуулалт хийж, түрээсийн орлого **183,82 сая** төгрөг, бусад ажил үйлчилгээнээс **119,4 сая** төгрөгийн орлого оруулсан байна.

Компанийн нийт борлуулалт 2022 онд **8 тэрбум 777 сая** төгрөг бөгөөд татварын өмнөх ашиг **1 тэрбум 949 сая** төгрөг , цэвэр ашиг **1 тэрбум 719 сая** төгрөг байна.

Дээрх нийт ашгийг үйл ажиллагааны чиглэлээр задалж харуулья. Үүнд: Барилга угсралтын ажлын ашиг **1 тэрбум 501** сая төгрөг, түрээсийн ашиг **183,82** сая төгрөг, бусад орлого **119,44** сая төгрөг, банкны хадгаламж, харилцахын хүүгийн ашиг **746,34** сая төгрөг, компанийн хэмжээнд ашигт ажиллагааны түвшин **17%** байна.

Энэ онд улсын төсөвт төлөх НӨАТ, аж ахуйн нэгжийн ашгийн татвар, хүн амын орлогын татвар, үл хөдлөх хөрөнгийн, газрын, тээврийн хэрэгслийн татварт **1 тэрбум 552,8** сая төгрөг, мөн нийгмийн даатгалын шимтгэлд **256.4 сая** төгрөг төлж, улсын татварын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байна.

2022 онд бизнес төлөвлөгөөгөөр компани нийт **6,52** тэрбум төгрөгийн ажил үйлчилгээ гүйцэтгэх ба үүнээс **6,18** тэрбум төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэж, **497,6** сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн ч нийт борлуулалт **8 тэрбум 777 сая** төгрөг бөгөөд цэвэр ашиг **1 тэрбум 719 сая** төгрөг байна нь төлөвлөгөөг биелүүлж ажилласныг харуулж байн.

Компани 2022 онд орон нутгийн хөрөнгөөр санхүүжих Сүхбаатар аймгийн Түрээсийн орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын тендерт оролцсон боловч татварын маргаантай асуудлын улмаас шалгарч чадсангүй.

Бид өнгөрсөн онд шинээр эхэлсэн болон урьд оны шилжсэн барилгуудад **17 тэрбум 540 сая** төгрөгийн угсралтын ажил гүйцэтгэж, Үүнээс томоохныг дурдвал:

1. Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний барилга угсралтын ажил **3 тэрбум 78 сая төгрөг**
2. Сэлбэ дэд төвийн дулааны станцын угсралтын ажил – **10 тэрбум 272 сая төгрөг**

Баянзүрх дүүрэгт баригдсан 84 айлын 15 давхар орон сууцыг 2020 оны 12-р сарын 10-нд улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтанд оруулсан бөгөөд 2022 онд **3 тэрбум 384 сая** төгрөгийн орон сууц борлууллаа.

Тайлант хугацаанд жилийн дунджаар **78** хүн ажиллаж, **1 тэрбум 36.2** сая төгрөгийн цалин олгож, компанийн ажилтны сарын дундаж цалин **1 сая 107.0** мянган төгрөг болж, өмнөх **/896.04** мян.төгрөг/ оныхоос **19%** буюу **211** мянган төгрөгөөр өсчээ.

Компанийн мөнгөн хөрөнгийн ашиглалтыг сайжруулахад анхаарч, харилцагч банкуудаас харилцахын үлдэгдэлд олгох хүүгийн хувь хэмжээний талаар санал авч, судалгаа хийсний үндсэн дээр хадгаламжид өндөр хүү олгож байгаа Төрийн банк, ХААН банканд мөнгөн хөрөнгийн ихэнх хэсгийг байршуулж, хугацаатай хадгаламжийн хүү авч байна. 2022 онд байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүд нийт **746,34 сая** төгрөгийн хүүгийн орлого авсан байна.

2022 онд мөнгөн хөрөнгийн ашиглалт, банкны хүүг нэмэгдүүлэх болон авлага, өглөгийг барагдуулах буюу эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд амжилттай ажилласан байна.

Компанийн “Барилгачин” сувиллыг 2022 оны 10-р сараас цэцэрлэгийн зориулалтаар түрээсэлсэн байгаа. Баянзүрх орон сууцны 1-р давхрын

цэцэрлэгийн зориулалтаар барьсан хэсгийг бас түрээсэлж үйл ажиллагаа явуулж байгаа.

Энэ онд спорт залны үйл ажиллагаа тогтворжиж 2022 оны 1-12 сард **94.7 сая** төгрөгийн орлого оруулсан байна. Мөн ашиглалтгүй байсан 1 давхар соёл үйлчилгээний барилгыг спорт заал болгон засварлан Хүрд Спорт заал 1,2 болгон ашиглаж байна.

Компанийн ашиглалтгүй буюу илүүдэлтэй ажлын байруудыг түрээсээр ажиллуулж, 2022 онд **183,82** сая төгрөгийн түрээсийн орлого оруулсан байна.

2022 онд Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн 3,0 тэрбум төгрөгийн ажлыг гүйцэтгэж, компанийн 2 давхрын өрөөнүүдэд засвар хийлээ.

2022 онд компанийн улирал, жилийн тайлан балансыг хугацаанд нь гаргаж, Аудитын байгууллагаар хяналт хийлгэж, Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо, Дүүргийн татвар, санхүүгийн хэлтэст тушааж ажиллаж байна.

Компанийн үйл ажиллагаа, эдийн засгийн үзүүлэлт, 2022 оны бизнес төлөвлөгөөний биелэлт, ТУЗ-ийн үйл ажиллагаа тогтворжсон зэргээс харахад компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хэвийн явагдаж, үүргээ биелүүлж ажилласан гэж үзэж байна.

2023 онд компанийн зорилтот үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Энэ оны ажлын ерөнхий чиглэл, зорилго дараах байдалтай байна. Үүнд:

2023 онд одоогоор хэрэгжүүлэх нь тодорхой байгаа Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн **2,3** тэрбум төгрөгийн ажлыг гүйцэтгэж, ашиглалтанд хүлээлгэн өгнө.

2023 онд Бизнес төлөвлөгөөгөөр **4,5** тэрбум төгрөгийн борлуулалт, **950** сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн.

Цаашид улс, орон нутгийн хөрөнгөөр санхүүжих барилга угсралтын ажлын тендерт оролцож ажил, үйлчилгээ олж авах шаардлагатай байгаа. Гэвч 2021-2022 оны цар тахал, олон улсын хямралт нөхцөл байдал, хил гааль, ачаа тээврийн хүндрэл, барилгын материалын үнийн өсөлт зэргээс шалтгаалан Монгол Улсын Засгийн Газраас төрийн хэмнэлтийн бодлого гарсаны улмаас 2022 оноос шинэ ажил үйлчилгээ, тендер, худалдан авалтыг хязгаарлаад байгаа нь барилга угсралтын ажлын тендерт оролцох, шинээр ажил үйлчилгээ, барилга угсралтын ажил эхлүүлэхэд хүндрэлтэй нөхцөл үүсээд байна.

Иймд компанийн удирдлагын зүгээс өөрсдийн үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, гадаад валют тодорхой түвшинд нөөцлөх, эргэлдүүлэх материалын нөөц бүрдүүлэх, банк санхүүгийн бүтээгдэхүүн ашиглах үүнд : Бонд, хувьцаа, хадгаламж, орон сууц барих, сантехникийн материалын худалдаа эхлүүлэх, зарим нэг үл хөдлөх хөрөнгө, үндсэн хөрөнгө оруулалтын судалгаа хийж эрсдэлээс хамгаалах шаардлага үүсээд байна. Мөн компанийн олон жилийн төсөл хөтөлбөрт оролцож байсан арвин их туршилага туулгуурлан гадаад худалдаа эрхлэх боломжтой талаар судлаж байна.

Мөн Үндэсний статистикийн хорооноос гаргасан салбарын дундаж цалин, хүн амын дундаж цалингаас Хүрд ХК-ийн ИТА нарын цалин доогуур байгааг улсын жишигт хүргэн нэмэгдүүлэх зорилт тавьж байна.

Компанийн “Хүрд-Орон сууц” салбар одоогоор 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр тогтвортой сайн ажиллаж байна.

Компанийн бетон эдлэлийн болон төмөр хийцийн цехийг бие даасан үйлдвэр ХХ Компани болгохоор төлөвлөсөн ч хэрэгжээгүй Хүрд ХК үндсэн бүтээн байгуулалтын ажилд оролцон ажиллаж байна. 2023 оноос Хүрд Бетон хийц үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний нэр төрлийг олшируулж, Бетон Зуурмагын үйлдвэрлэлийг өргөжүүлэх судалгаа хийгдэж байна.

2022 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн түвшинд явагдаж, санхүүгийн тогтвортой байдлаа хадгалж, төлөвлөгөөт зорилтуудаа амжилттай биелүүлснийг харуулж байна.

Компанийн 2022 оны удирдлагын зардлын зарцуулалт, инфляцийн түвшинг харгалзан 2023 оны удирдлагын зардлыг **525 сая** төгрөгөөр төлөвлөж байна.

Ажлын үр дүн, компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд хангалттай гэсэн дүгнэлтийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл өгч хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Мөн 2023 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлуулахаар хуралд хэлэлцүүлж байгаад санал бодлоо илэрхийлж баталж өгөхийг хүсье.

Та бүхэнд эрүүл энх, ажлын амжилт хүсэн ерөөе.

Хүрд ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл